



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 4/23

Мандалговь

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14, 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Тэвш 9-н эрдэнэ ХХК-ны “Бөөний төв”, Анут хийморь трейд ХХК-ны “Дундговь худалдааны төв”, иргэн Ц.Цэнгэлмаагийн “мухлаг”-т тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 03 –ны өдрийг хүртэл хугацаагаар олгосугай.

2. Утаат тамхи худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэхдээ хууль, журамд заасан тавигдах шаардлагыг биелүүлж ажиллахыг “Тэвш 9-н эрдэнэ” ХХК-ны захирал (Б.Даваадамдин), “Анут хийморь трейд” ХХК-ны захирал (Н.Мэндсайхан), Иргэн (Ц.Цэнгэлмаа) -нарт үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн (Б.Саранзаяа), хэсгийн мөрдөгч, цагдаагийн ахмад (Б.Амарбаяр), сумын хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч (Б.Билгүүн) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГТОХ

